

Засаг даргын Тамгын газрын даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2025 оны
09 дугаар сарын 15-ны өдрийн А/10 тоот
тушаалын хавсралт

Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийг
угтаж хийх ажлын төлөвлөгөө

№	Хийгдэх ажил	Хугацаа	Хариуцах эзэн
1	Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх сумын болон байгууллагын ажлын хэсгийг томилсон захирамж, тушаалыг боловсруулах	2025-09-20	Ажлын хэсгүүд
2	"Архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагуудын ажлын зохион байгуулалт" улсын үзлэгт бэлтгэх төлөвлөгөө боловсруулж байгууллагын даргаар батлуулах	2025-09-20	Байгууллагын комисс
3	Аймгийн Засаг даргын 2019 оны А/20 тоот захирамжийг хэрэгжүүлэн ажиллах талд анхаарч ажиллах	2025-09-20	Сумын комисс
4	Өмнөх оны баримтыг эмхлэн цэгцэлж тоо бүртгэлийг заавар журмын дагуу хийж гүйцэтгэсэн байх	2025-03-31	Архив, бичиг хэргийн ажилтан Б.Сансармаа, Байгууллагын комисс
5	Архивын баримтын нөхөн бүрдүүлэлтэд анхаарч зохион байгуулалтын нэгжүүдээс баримтыг хүлээн авч бүртгэл хөтлөх	2025-03-31	Архив, бичиг хэргийн ажилтан Б.Сансармаа
6	Байгууллагын ажилтнуудад архив, албан хэрэг хөтлөлтийн талаар сургалт явуулах		Архив, бичиг хэргийн ажилтан Б.Сансармаа
7	Байгууллагын архивын өрөө тасалгаанд засвар үйлчилгээ хийх	2025-05-20	ЗДТГазрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Бүдханд, Архив, бичиг хэргийн ажилтан Б.Сансармаа



**ХЭНТИЙ АЙМГИЙН БАТШИРЭЭТ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 09 сарын 15 өдөр

Дугаар A/10

Батширээт сум

Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын
үзлэгт бэлтгэх байгууллагын ажлын хэсэг
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, Засгийн газрын 2025 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн “Улсын үзлэг зохион байгуулах тухай” 23 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын 2025 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн А/514 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийн бэлтгэл ажлыг хангах ажлын хэсгийг доорхи бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Дарга: Б.Сансармаа- Архив, бичиг хэргийн ажилтан
Гишүүдэд: Ж.Ундрах- Мал эмнэлгийн Улсын байцаагч
Б.Энхболор- Хүнс,Хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэл,
хоршоо хариуцсан мэргэжилтэн
Б.Ариунболор- Хууль эрх зүйн мэргэжилтэн
Г.Бат-Эгшиглэн-Иргэний танхимын ажилтан
Б. Номинжаргал-Нярав

2. Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

3. Улсын үзлэгт бэлтгэх ажилд шаардлагатай хөрөнгийг зарцуулж ажиллахыг нягтлан бодогч (Б.Цолмон)-д зөвшөөрсүгэй.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.БҮДХАНД



232505010